



2020 оны 06 дугаар сарын 23
№24 /1126/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын Засгийн газрын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Тогтоолын хавсралт шинэчлэн
батлах, хавсралтад өөрчлөлт
оруулах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

273.	Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай		1218
274.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1218
275.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1222
276.	Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт орлуулах тухай		1223
277.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		1223
278.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай		1224

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

279.	Журам батлах тухай	Дугаар 50	1224
280.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт орлуулах тухай	Дугаар 51	1226
281.	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тусгай хэрэгцээнээс гаргах тухай.	Дугаар 53	1227

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

282.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 34	1229
------	--	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

283.	Журам батлах тухай	Дугаар 464	1229
------	--------------------	------------	------



284.	Тогтоолын хавсралт шинэчлэн батлах, хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 465	1237
МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ			
285.	“Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”		1242
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр			Улаанбаатар хот
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ			
<p>1 дүгээр зүйл.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулсан “Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.</p>			
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА		Г. ЗАНДАНШАТАР	
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр			Улаанбаатар хот
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ			
<p>1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:</p>			

1/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

“2/Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулахдаа захирамж гаргана;”

2/30 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“10.Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах аргачлалыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн Засгийн газар батална.”

3/36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Засгийн газар албан ёсны бэлгэдэлтэй байх бөгөөд “Засгийн газар” гэсэн нэршил, бэлгэдлийг иргэн, хуулийн этгээд хэрэглэхийг хориглоно.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.” гэсний дараа “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн 2 дахь өгүүлбэр, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх бөгөөд тангараг өргөх журмыг Улсын Их Хурал тогтооно. Засгийн газрын гишүүн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө.” гэсэн 2, 3 дахь өгүүлбэр, 36 дугаар зүйлийн гарчгийн “тэмдэг” гэсний дараа “, бэлгэдэл” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйл:

“4 дүгээр зүйл.Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам

1.Засгийн газрыг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай



хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн Аравдугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу эмхлэн байгуулна.

2.Ерөнхий сайдыг огцруулах, шинээр томилох, чөлөөлөх болон Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай асуудлыг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Дөчин гуравдугаар зүйл, Дөчин дөрөвдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн Аравдугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу Улсын Их Хурал шийдвэрлэнэ.”

2/21 дүгээр зүйл:

“21 дүгээр зүйл.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа

1.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байх бөгөөд Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.

2.Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоолыг баталсан тохиолдолд Ерөнхий сайд огцорно.

3.Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

4.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас чөлөөлөгдсөн, огцорсон, түүнчлэн нас нөгчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно. Ерөнхий сайд чөлөөлөгдсөн, огцорсон, нас нөгчсөн тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно.

5.Засгийн газрын гишүүний орон гарсан тохиолдолд Ерөнхий сайд түүнийг энэ хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан журмын дагуу 14 хоногийн дотор нөхөн томилно. Нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

6.Ерөнхий сайдын бүрэн эрх биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсны улмаас чөлөөлөгдсөн, нас нөгчсөн үндэслэлээр хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг Шадар сайд гүйцэтгэнэ.

7.Засгийн газрын орон гарсан гишүүнийг нөхөн томилох хүртэл Ерөнхий сайд Засгийн газрын нэг гишүүнд түүний үүргийг хуваарилан хариуцуулж болно.

8.Бүрэлдэхүүнээрээ огцорсон Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнийг дахин томилж болно.”

3/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“1/Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон тэдгээрт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд Ерөнхийлөгчтэй зөвшилцөж чадаагүй тохиолдолд Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ;”

4/26 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэг:

“1.Засгийн газар Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байвал зохино.

2.Ерөнхий сайд Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолын төслийг өргөн мэдүүлэхдээ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, төсөв тэдгээрийн зүйл, хэсэг, заалтын талаарх өөрийн байр суурь болон Улсын Их Хурлаас дэмжлэг хүсэж байгаа асуудлыг тодорхой илэрхийлсэн байна. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайд огцорно.

3.Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолыг баталсан бол энэ хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлыг дэмжсэнд тооцно. Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх асуудлыг 6 сарын дотор дахин санаачлахгүй.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хариуцна. Түүний дотор” гэснийг “хариуцаж, дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 2-8 дахь заалтын дугаарыг “3-9” гэж, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “Ерөнхий сайд, улмаар Улсын Их Хурлын” гэснийг “Ерөнхий сайдын” гэж, 26 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “Засгийн газрын гишүүн” гэснийг “Ерөнхий сайд” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



6 дугаар зүйл.Энэ хуулийг Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах талаар Ерөнхий сайдаас ирүүлсэн саналтай танилцана.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхыг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.”

3 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.2.9.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 15.31 дүгээр зүйл нэмсүгэй:

“15.31 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль зөрчих

1.Монгол Улсын Засгийн газрын албан ёсны нэр, бэлгэдлийг хэрэглэсэн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол Улсын Засгийн газрын албан ёсны нэр, бэлгэдлийг хэрэглэж худал мэдээлэл тараасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,” гэсний дараа “15.31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ
ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүн томилогдсоноосоо хойш ажлын 3 өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд тангараг өргөнө.

2. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх өдөр, цагийг Монгол Улсын Ерөнхий сайдын саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга тогтооно.

3. Тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэл ажлыг Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн ёслолын алба хариуцан хангаж, зохион байгуулна.

4. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд төр, захиргаа, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчдийг урилгаар оролцуулж болно.

5. Тусгайлан бэлдсэн ширээн дээр Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьсан байна.

6. Тангаргийн бичигт Монгол Улсын Төрийн сүлд, түүний дор тангаргийн бүрэн бичвэр, тангараг өргөсөн гишүүний овог, нэр, он, сар, өдрийг тусгана.

7. Засгийн газрын гишүүн товлосон өдөр, цагт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд орж, Монгол Улсын Төрийн сүлд рүү харан цэх зогсох ба хамтаар тангараг өргөх бол эгнэн зогсоно.

8. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулсны дараа Засгийн газрын гишүүн тангараг өргөнө.

9. Тангараг өргөсний дараа Засгийн газрын гишүүн төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, чуулганы танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурна.

10. Засгийн газрын гишүүн тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу тангаргийг ээлжээр уншина.

11. Засгийн газрын гишүүн тангаргийн бичигт гарын үсэг зурж Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулна.



12.Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж дууссаны дараа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд Төрийн дуулал эгшиглүүлнэ.

13.Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Засгийн газрын гишүүдэд баяр хүргэж үг хэлэн ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан “Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийн “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” хэсгийн “Эрхэлсэн түшмэл” гэсэн ангиллын “АА-4” зэрэглэлийн “Албаны дарга, ахлах зөвлөх” гэснийг “Албаны дарга, Засгийн газрын ахлах референт” гэж, “АА-5” зэрэглэлийн “Зөвлөх, ахлах референт” гэснийг “Засгийн газрын референт” гэж, “Ахлах түшмэл” гэсэн ангиллын “АА-6” зэрэглэлийн “Референт” гэснийг “Ахлах шинжээч” гэж, “АА-7” зэрэглэлийн “Ахлах шинжээч” гэснийг “Шинжээч” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Мөн хавсралтын “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” хэсгийн “Ахлах түшмэл” ангиллын “АА-8” зэрэглэлийн “Шинжээч” гэснийг хассугай.

3.Энэ тогтоолыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 53

Улаанбаатар
хот

Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тусгай хэрэгцээнээс гаргах тухай

Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд олгосон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших газрын хилийн зааг, эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг 1 дүгээр хавсралтаар баталж, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 90 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар улсын тусгай хэрэгцээнд авсан Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны газрын зарим хэсгийг улсын тусгай хэрэгцээнээс гаргаж, шинэчлэн тогтоосон хилийн зааг, эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Гадаад улсын дипломат болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газартай харилцан адил байх зарчмыг баримтлан Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 90 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
53 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ, ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ, ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

Эргэлтийн цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг			Хаяг, байршил	Талбайн хэмжээ /м.кв/
1	47	53	51.460	106	55	56.434		39967



2	47	53	47.354	106	55	59.795	Хан-Уул дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам
3	47	53	46.720	106	55	52.865	
4	47	53	46.112	106	55	46.233	
5	47	53	51.042	106	55	43.522	
6	47	53	51.238	106	55	49.571	

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
53 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА
ЭЛЧИН САЙДЫН ЯАМНЫ ГАЗРЫН ШИНЭЧЛЭН ТОГТООСОН
ХИЛИЙН ЗААГ, ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ,
ТАЛБАЙН ХЭМЖЭЭ**

Эргэлтийн цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг			Хаяг, байршил	Талбайн хэмжээ /м.кв/
1	47	55	38.0316	106	55	47.4672	Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам	26211
2	47	55	38.0064	106	55	46.8444		
3	47	55	38.37	106	55	46.7868		
4	47	55	38.3736	106	55	46.6176		
5	47	55	38.7624	106	55	46.5636		
6	47	55	38.7696	106	55	46.6644		
7	47	55	38.8848	106	55	46.6464		
8	47	55	39.8496	106	55	46.4844		
9	47	55	41.7792	106	55	46.1568		
10	47	55	43.6116	106	55	45.8508		
11	47	55	43.8276	106	55	45.8112		
12	47	55	43.8312	106	55	45.8436		
13	47	55	44.076	106	55	49.494		
14	47	55	44.1372	106	55	50.5992		
15	47	55	44.7816	106	55	50.5308		
16	47	55	44.7744	106	55	52.4676		
17	47	55	37.668	106	55	52.5324		
18	47	55	37.4592	106	55	47.5392		

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан шүүгч Цэнджавын Байгалмааг Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар: 464

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журам батлагдсантай холбогдуулан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”-ыг боловсруулж батлахыг Тагнуулын ерөнхий газар (Д.Гэрэл)-т зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Тагнуулын ерөнхий газар (Д.Гэрэл)-т даалгаж, Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нарт зөвлөсүгэй.



4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2019 оны
464 дүгээр тогтоолын хавсралт

**ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН
ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ
ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь терроризм, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон эдгээр гэмт хэргийг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэхтэй холбогдуулж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл (цаашид “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл” гэх)-өөс гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хүн, хуулийн этгээдийг террорист этгээдийн жагсаалт (цаашид “жагсаалт” гэх)-д оруулах, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, жагсаалтад оруулснаас үүсэх бусад харилцааг зохицуулах, гуравдагч этгээдийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.

1.3. Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан Монгол Улсад хамааралтай тогтоолд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалт, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолыг дагаж мөрдөнө.

Хоёр. Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах

2.1. Энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлалд заасан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон түүний хорооноос гаргасан тогтоолын



дагуу жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд холбогдох арга хэмжээг шууд хэрэгжүүлнэ.

2.2. Засгийн газар тагнуулын байгууллагын саналыг үндэслэн өөрийн санаачилгаар, эсхүл гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг үндэслэн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын зохих шалгуурт нийцсэн гэж үзэх үндэслэлтэй бол хүн, хуулийн этгээдийг даруй жагсаалтад оруулна.

2.3. Энэ журмын дагуу аливаа хүн, хуулийн этгээдтэй холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн эсэхээс үл хамааран тэдгээрийг жагсаалтад оруулж болно.

2.4. Тагнуулын байгууллага болон Терроризмтой тэмцэх зөвлөл жагсаалтыг холбогдох эрх бүхий байгууллага болон нийтэд шуурхай мэдээлж, албан ёсны цахим хуудсанд даруй байршуулна.

2.5. Уг жагсаалтыг нийтэд мэдээлснээс хойш тагнуулын байгууллага ажлын 15 өдрийн дотор жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд дараах мэдээллийг хүргүүлнэ:

2.5.1. жагсаалт, түүний болзошгүй үр дагавар;

2.5.2. жагсаалттай танилцах, жагсаалтаас хасахтай холбоотой мэдээлэл;

2.5.3. тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах болсон баримтын нийтэд мэдээлж болох тодорхой хэсэг;

2.5.4. санхүүгийн үйлчилгээ авах болон хөрөнгийг ашиглах зөвшөөрөл авахтай холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын тухай мэдээлэл;

2.5.5. жагсаалтаас хасуулах тухай гомдлыг хүлээн авах НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооны мэдээлэл.

2.6. Тагнуулын байгууллага нь энэ журмын 2.2-т заасны дагуу хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах санал гаргахдаа эрх бүхий хяналт шалгалтын, хууль сахиулах болон холбогдох бусад байгууллага, ижил төстэй гадаадын байгууллага болон үндэслэл бүхий эх сурвалжийн мэдээ, мэдээллийг ашиглаж болно.

2.7. Тагнуулын байгууллага жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд болон түүний хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоохтой холбоотой аливаа ажиллагааг урьдчилан мэдэгдэлгүйгээр гүйцэтгэнэ.



2.8. Терроризмтой тэмцэх зөвлөл, тагнуулын байгууллага нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон энэ журамд заасан санхүүгийн хориг арга хэмжээг бодлогын түвшинд хэрэгжүүлж, хяналт шалгалт, хууль сахиулах асуудал хариуцсан болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

2.9. Энэ журмын 2.2-т заасны дагуу жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээд нь гадаад улстай холбоотой гэж тагнуулын байгууллага үзвэл шаардлагатай мэдээллийг тухайн улсын ижил төстэй байгууллагад гарган өгч болно.

Гурав. Жагсаалтад санал оруулах

3.1. Тагнуулын байгууллага нь энэ журамд заасан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол болон холбогдох бусад тогтоолд заасан шалгуурт нийцсэн гэсэн үндэслэлээр хүн, хуулийн этгээдийг шинээр жагсаалтад оруулах хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзвэл энэ тухай саналаа Засгийн газарт танилцуулж, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хороонд хүргүүлж болно.

3.2. Энэ журмын 3.1-д заасны дагуу жагсаалтад оруулах саналыг дараах байдлаар боловсруулна:

3.2.1. жагсаалтад оруулахтай холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос баталсан журмыг баримтлах;

3.2.2. жагсаалтад шинээр оруулах хүн, хуулийн этгээдийн нэртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл болон тухайн этгээдийг үнэн зөв тодорхойлоход шаардагдах хангалттай бодит мэдээллийг бүрдүүлж, Интерпол, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тусгай мэдэгдлийн шаардлагыг хангах;

3.2.3. хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах үндэслэл, шалтгаан, шалгуурт нийцсэн тухай дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримт бичиг болон жагсаалтад оруулахаар санал болгож байгаа хүн, хуулийн этгээд нь жагсаалтад байгаа бусад этгээдтэй холбоо хамааралтай эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хэргийн танилцуулгыг бэлтгэх.

3.3. Монгол Улсыг жагсаалтад санал оруулж байгаа улс гэдгийг нийтэд мэдэгдэх эсэх асуудлаар тагнуулын байгууллага нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөнө.

Дөрөв. Жагсаалтаас хасах, хөрөнгө чөлөөлөх

4.1. Энэ журмын 2.1-д заасны дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан жагсаалттай холбогдуулж, уг жагсаалтаас хасах болон хөрөнгө чөлөөлөхтэй холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1.1. тагнуулын байгууллага жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг жагсаалтад орох шалгуурт нийцээгүй, эсхүл цаашид нийцэхгүй гэж үзэх үндэслэлтэй бол саналаа Засгийн газарт танилцуулж НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл эсхүл түүний хороодод жагсаалтаас хасах тухай хүсэлт тавих;

4.1.2. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хороонд хандан жагсаалтаас хасах тухай гомдол гаргах;

4.1.3. хүн, хуулийн этгээдийн жагсаалтаас хасах тухай гомдлыг тагнуулын байгууллага хүлээн авч, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон түүний холбогдох хорооны жагсаалтад орох шалгуурт нийцээгүй эсхүл цаашид нийцэхгүй гэж үзэх үндэслэлтэй бол түүний гомдлыг дэмжих.

4.2. Энэ журмын 2.2-т заасны дагуу жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийг жагсаалтаас хасах болон түүний хөрөнгийг чөлөөлөхтэй холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.2.1. жагсаалтад оруулсныг эс зөвшөөрч байгаа хүн, хуулийн этгээдийн гомдлыг тагнуулын байгууллага хянан шийдвэрлэх;

4.2.2. тагнуулын байгууллага энэ журмын 4.2.1-д заасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ шаардлагатай мэдээлэл авах, тодорхой асуултад хариулт авах зорилгоор гомдол гаргагчаас нэмэлт тайлбар авах;

4.2.3. тагнуулын байгууллага энэ журмын 4.2.1-д заасан гомдлыг хянахын зэрэгцээ, өөрийн санаачилгаар жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн мэдээллийг жагсаалтад оруулах шалгуурт нийцэх эсэхийг 5 жил тутам хянан баталгаажуулах;

4.2.4. тагнуулын байгууллага энэ журмын 4.2.1, 4.2.3-т заасан ажиллагааны үр дүнд жагсаалтад оруулах шалгуурт нийцээгүй, эсхүл цаашид нийцэхгүй гэж үзвэл уг хүн, хуулийн этгээдийг даруй жагсаалтаас хасах саналаа Засгийн газарт танилцуулах.

4.3. Хүн, хуулийн этгээд Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.6-д, эсхүл энэ журмын



2.1, 2.2-т заасны дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээнд үндэслэлгүйгээр өртсөн гэж үзвэл тагнуулын байгууллагад хөрөнгийг чөлөөлөх тухай гомдол гаргана. Гомдлыг ажлын 30 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

4.4. Тагнуулын байгууллага энэ журмын 4.3-т заасны дагуу хүлээн авсан гомдлыг хянаж, гомдол гаргагч нь жагсаалтад ороогүйг нягтлан шалгасны үндсэн дээр хөрөнгийг чөлөөлөх шийдвэр гаргаж болно.

4.5. Энэ журмын 2.1, 2.2-т заасны дагуу жагсаалтад орсон этгээдийн мөнгөн хуримтлал, хөрөнгөөс тэдгээрийн үндсэн хэрэглээний зардал, тодорхой төрлийн төлбөр, нэн шаардлагатай зардал, үйлчилгээний хураамж буюу гэнэтийн зайлшгүй зардал зэргийг төлж барагдуулах шаардлагатай эсэх асуудлыг тагнуулын байгууллага хянаж, шийдвэрлэнэ.

4.6. Энэ журмын 4.5-д заасан шийдвэрийг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд заасны дагуу хэрэгжүүлнэ.

4.7. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн болон энэ журамд заасан жагсаалтаас хассан, эсхүл хөрөнгийг чөлөөлсөн тухай шийдвэр гарсан даруй тагнуулын байгууллага нь холбогдох хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч бусад этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

4.8. Тагнуулын байгууллага, Терроризмтой тэмцэх зөвлөл нь жагсаалтаас хассан, хөрөнгийг чөлөөлсөн тухай энэ журмын 4.7-д заасан шийдвэрийг даруй хэрэгжүүлж, албан ёсны цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

4.9. Тагнуулын байгууллага энэ журамд заасан үүргээ хэрэгжүүлэх явцад хууль ёсны гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.9.1. энэ журмын 2.1, 2.2-т заасан жагсаалтад оруулсны улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдийн хөрөнгө чөлөөлүүлэхийг хүссэн гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх;

4.9.2. энэ журмын 4.9.1-д заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор шийдвэрлэж, холбогдох талуудад мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 30 хүртэл өдрөөр сунгах.

4.10. Тагнуулын байгууллага энэ журмын 4.9-д заасан гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор нэмэлт мэдээлэл авах, тодорхой асуултад хариулт авахын тулд гомдол гаргагч болон холбогдох бусад этгээдийг дуудан ирүүлэх эрхтэй.



4.11. Энэ журмын дагуу тагнуулын байгууллагын гаргасан аливаа шийдвэрийг хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн этгээд зохих эрх бүхий байгууллагаар хянуулах эрхтэй.

Тав. Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох болон хориглох

5.1. Хүн, хуулийн этгээд нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогын хөдөлгөөнийг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдэгдэнэ.

5.2. Хүн, хуулийн этгээд нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсхүл түүнийг төлөөлж байгаа этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

5.3. Хүн, хуулийн этгээдээс энэ журмын 5.1, 5.2-т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг зогсооно:

5.3.1. зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүх мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;

5.3.2. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүх мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;

5.3.3. энэ журмын 5.3.1, 5.3.2-т заасан хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;

5.3.4. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолоор жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл.

5.4. Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоосон хүн, хуулийн этгээдийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой төлбөр, хүүгийн болон бусад төлбөрийг мөн адил зогсооно.

5.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд энэ журмын дагуу хөрөнгийн



хөдөлгөөнийг зогсоох, түүнтэй холбогдсон бусад арга хэмжээ авсан бол энэ талаар тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлалд заасан маягтын дагуу мэдээлнэ.

5.6. Хүн, хуулийн этгээд энэ журмын 5.5-д заасны дагуу тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албаны шаардсан нэмэлт мэдээллийг даруй гаргаж өгөх үүрэгтэй.

5.7. Санхүүгийн мэдээллийн алба энэ журмын 5.6-д заасны дагуу авсан мэдээллийг тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавих шаардлага

6.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь дараах шаардлагыг мөрдөнө:

6.1.1. жагсаалтад орсон, хасагдсан хүн, хуулийн этгээд болон зогсоосон хөрөнгийг чөлөөлөх мэдээлэлтэй өөрийн харилцагчдын мэдээллийг тулгаж шалгасны үндсэн дээр үйлчилгээ үзүүлэх;

6.1.2. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хяналтад байгаа, түүний заавраар үйл ажиллагаа явуулдаг эсэхийг тогтоох санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шалгуурыг бий болгож харилцагчийг таньж мэдэх ажиллагаанд ашиглах;

6.1.3. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хяналтад байгаа, түүний заавраар санхүүгийн гүйлгээ хийж байгаа эсэхийг тогтоох санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх шалгуурыг бий болгож гүйлгээний хяналтын ажиллагаанд ашиглах;

6.1.4. өндөр эрсдэлтэй харилцагчид болон түүний харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан ажиллагааг хэрэгжүүлэх;

6.1.5. холбогдох ажилтнуудад санхүүгийн зорилтот арга хэмжээ болон холбогдох хууль, тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах.

6.2. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа жагсаалтаа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон Засгийн газраас баталсан дотоодын жагсаалтад нийцүүлэн тогтмол шинэчилнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 465

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралт шинэчлэн батлах, хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 47.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 342 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам”-ын 2.7 дахь заалтын “47.1.2” гэснийг “47.2.1” гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолоор баталсан журамд нийцүүлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн маягыг шинэчлэн баталж, мөрдүүлэхийг Татварын ерөнхий газар (Б.Заяабал)-т даалгасугай.

4. Энэ тогтоолыг мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газар (Б.Заяабал), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү)-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2019 оны 465 дугаар
тогтоолын хавсралт

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВИЙГ ТООЦОХ, ТӨЛБӨР НОГДУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ТӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (цаашид “АМНАТ” гэх) төлөгчийн худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүнд

АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцох, төлбөр ногдуулах, төлөх, тайлагнахад энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг тооцох

2.1. АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг дараах байдлаар тооцно:

2.1.1. тухайн сард дотоодын зах зээлд худалдсан, худалдахаар ачуулсан, өөрийн хэрэгцээнд ашигласан ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг баримтлан;

2.1.2. тухайн сард экспортолсон, экспортлохоор ачуулсан ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.1-д заасны дагуу Засгийн газраас тогтоосон үнийн эх сурвалжид үндэслэн нийтэд мэдээлсэн үнийг баримтлан;

2.1.3. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алт болон мөнгөний борлуулалтын үнэлгээг Монголбанкнаас тухайн өдөр зарласан үнийг баримтлан.

2.2. Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний агуулгын хувь нь Засгийн газраас тогтоосон үнийн эх сурвалжид үндэслэн нийтэд мэдээлсэн тухайн ашигт малтмалын агуулгын хувиас ялгаатай тохиолдолд нийтэд мэдээлсэн жишиг үнийн мэдээлэлд заасан агуулгын хувь, үнээс тухайн ашигт малтмалын нэгж агуулгын хувьд ногдох үнийг тодорхойлон борлуулж байгаа ашигт малтмалын агуулгын хувь, хэмжээнд хувь тэнцүүлэх зарчмаар борлуулалтын үнэлгээг тооцно.

2.3. Дотоодын зах зээлд борлуулж байгаа бүх төрлийн ашигт малтмалын агуулга, түүний хувь, шинж чанар, ангиллыг лабораторийн дүгнэлтэд үндэслэн тодорхойлно. Лаборатори нь Монгол Улсын, эсхүл олон улсын итгэмжлэгдсэн лаборатори байна.

2.4. Гадаадын зах зээлд борлуулж байгаа бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний агуулга, түүний хувь, шинж чанар, ангиллыг Гаалийн лабораторийн дүгнэлтэд үндэслэн тодорхойлно.

2.5. Гаалийн лаборатори нь энэ журмын 2.4-т заасан дүгнэлтийг гаргахад олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж болно.

2.6. Гаалийн байгууллага экспортод гарсан ашигт малтмалын нэр, төрөл, агуулгын хувь хэмжээ, шинж чанарын, экспортлогчийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр татварын байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.



2.7. Ашигт малтмалын бүтээгдэхүүний лабораторийн дүгнэлтэд үндэслэн ашигт малтмалд АМНАТ ногдуулна.

2.8. Нүүрснээс бусад ашигт малтмалын бүтээгдэхүүнд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг лабораторийн шинжилгээний дүгнэлтээр тодорхойлсон агуулгын цэвэр хувь, хэмжээнд үндэслэн үндсэн болон дагалдах металл, эрдэс бүтээгдэхүүн тус бүрээр тооцно.

2.9. Энэ журамд заасны дагуу тооцсон борлуулалтын үнэлгээнээс тухайн бүтээгдэхүүнийг боловсруулах, хайлуулах, цэвэршүүлэх, тээвэрлэхтэй холбогдон гарах зардал болон аж ахуйн үйл ажиллагааны бусад зардлыг хасаж тооцохгүй.

Гурав. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах

3.1. Энэ журмын 2 дахь хэсэгт заасны дагуу тодорхойлсон борлуулалтын үнэлгээнд Ашигт малтмалын тухай хуулийн 47.3, 47.5, 47.17, 47².2, 47³.1, 47³.2 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр АМНАТ ногдуулна.

3.2. Ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах металл болон эрдэс бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.5 дахь хэсэгт заасан боловсруулалтын түвшний “бүтээгдэхүүн” ангиллын хувь хэмжээгээр, 47.17 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүний нэр төрлийн “эцсийн бүтээгдэхүүн” ангиллын хувь хэмжээгээр тус тус тооцож ногдуулна.

3.3. Хувь хүн, хуулийн этгээд нь ашигт малтмалыг “уурхайн ам” (EXW) нөхцөлөөр оршин суугч бус этгээдэд худалдсан, худалдахаар ачуулсан тохиолдолд тухайн ашигт малтмалыг экспортолсонд тооцож, АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг энэ журмын 2.1.2-т заасны дагуу тодорхойлно.

3.4. Ашигт малтмалыг дотоодын зах зээлээс худалдан авч шууд, эсхүл ашигт агуулгыг нэмэгдүүлэн баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлоход төлбөрийг давхардуулан ногдуулахгүй бөгөөд тухайн ашигт малтмалд төлбөр ногдуулах үнэлгээ, хувь хэмжээнээс хамаарч Ашигт малтмалын тухай хуулийн 47.18-д заасан төлбөрийн баримт болон мөн хуулийн 47.19-д заасны дагуу суутган төлсөн тайлан мэдээг үндэслэн өмнө нь ногдуулсан, суутган төлсөн төлбөрийг хасаж тооцно.

3.5. Энэ журмын 3.4-т зааснаар ашигт малтмалыг дотоодын зах зээлээс худалдан авч шууд, эсхүл ашигт агуулгыг нэмэгдүүлэн баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлоход зөвхөн тухайн ашигт малтмалд, эсхүл тухайн ашигт малтмалын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилгоор худалдан авсан ашигт малтмалын бүтээгдэхүүнд өмнө нь ногдуулсан төлбөрийг хасаж тооцно.



3.6. Энэ журмын 3.4, 3.5-д заасны дагуу ашигт малтмал экспортлогч этгээдийн экспортолсон ашигт малтмалд АМНАТ ногдуулах үнэлгээнээс тухайн ашигт малтмал, эсхүл тухайн ашигт малтмалын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилгоор дотоодын зах зээлээс худалдан авсан ашигт малтмалд АМНАТ ногдуулсан үнэлгээ илүү гарсан тохиолдолд экспортлогч этгээдэд нэмж төлбөр ногдуулахгүй.

3.7. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авсан Ашигт малтмалын тухай хуулийн 47.1.3-т зааснаас бусад төлбөр төлөгч нь худалдан авсан ашигт малтмалд энэ журмын 2.1.1-д заасан үнэлгээнээс тооцож АМНАТ-ийг суутган авч төсөвт шилжүүлнэ.

3.8. Олборлосон бүтээгдэхүүнээ өөрийн хэрэгцээнд ашигласан тохиолдолд тухайн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд борлуулсантай адилтгаж олборлогч этгээд нь тухайн бүтээгдэхүүнд энэ журмын 2.1.1-д заасны дагуу тодорхойлсон үнэлгээнээс тооцож АМНАТ ногдуулна.

3.9. Эдэлбэр талбайд орших АМНАТ ногдоогүй ашигт малтмалыг өөр бусад этгээдэд худалдах, ашиглуулах замаар гадаад, дотоодын зах зээл дээр борлуулсан нь АМНАТ төлөгчийг тухайн ашигт малтмалын нөөцөд ногдох АМНАТ төлөх үүргээс чөлөөлөхгүй.

3.10. Засгийн газрын тогтоосон үнийн эх сурвалжид үндэслэн нийтэд мэдээлсэн ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг тухайн үнэ зарласан сарын өмнөх сард экспортолсон, экспортлохоор ачуулсан ашигт малтмалд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тодорхойлоход ашиглана.

Дөрөв. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт төлөх, тайлагнах

4.1. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдээс бусад АМНАТ төлөгч нь худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан бүх төрлийн ашигт малтмалд ногдох тухайн сарын АМНАТ-ийг дараагийн сарын 20-ны өдрийн дотор улсын төсөвт төлнө.

4.2. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь худалдан авсан алт, мөнгөнд ногдох АМНАТ-ийг татвар төлөгчийн дугаарт үндэслэн энэ журмын 2.1.3-т заасан борлуулалтын үнэлгээнээс суутган авч, тухайн өдөрт багтаан улсын төсөвт шилжүүлнэ.

4.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдээс ашигт малтмал худалдан авч экспортолсон этгээд нь тухайн худалдан авсан ашигт малтмалд ногдох АМНАТ-ийг энэ журмын 2.1.1-д заасан борлуулалтын үнэлгээнээс суутган авч, дараагийн сарын 20-ны өдрийн дотор улсын төсөвт шилжүүлж, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй

этгээдийн татвар төлөгчийн дугаарт үндэслэн суутган авсан төлбөрийг АМНАТ-ийн тайлан, мэдээнд тусгана.

4.4. Монголбанкнаас эрх олгосон арилжааны банк нь худалдан авсан алт, мөнгийг гадаадын зах зээлд борлуулах тохиолдолд тухайн бүтээгдэхүүнд ногдох нэмэлт төлбөрийг энэ журмын 2.1.2-т заасан үнэлгээнээс Ашигт малтмалын тухай хуулийн 47.5 дахь хэсэгт заасан хувь, хэмжээгээр тооцож энэ журмын 4.1-д заасан хугацаанд улсын төсөвт төлж, АМНАТ-ийн тайланг энэ журмын 4.5-д заасан хугацаанд гаргаж харьяалах татварын албанд хүргүүлнэ.

4.5. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан хувь хүнээс бусад ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан этгээд нь АМНАТ-ийн тайланг татварын албанаас баталсан маягт, түүний хавсралт мэдээний дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.

4.6. Энэ журмын 4.5-д заасан хавсралт мэдээнд ашигт малтмалыг дамжуулан борлуулагч этгээдэд ашигт малтмал борлуулагч этгээдийн нэр, татвар төлөгчийн дугаар, тайлант хугацаа, тусгай зөвшөөрлийн дугаар, худалдах, худалдан авах гэрээний дугаар, цахим төлбөрийн баримтын дахин давтагдахгүй төлбөрийн дугаар, ашигт малтмалын нэр төрөл, ангилал, агуулгын хувь, тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, төлбөр ногдуулсан хувь, ногдуулсан төлбөрийн дүн, суутгасан төлбөрийн мэдээллийг тусгана.

4.7. Төлбөр төлөгч нь энэ журмын 4.5-д заасан хавсралт мэдээг ирүүлээгүй, үнэн зөв гаргаагүй, ирүүлсэн боловч ашигт малтмалыг анх борлуулсан этгээд нь экспортлогч этгээдэд дотоодын зах зээлд борлуулсан ашигт малтмалын мэдээллээ тайлан, мэдээнд тусгаагүй, төлбөр төлөгч нь АМНАТ-ийг суутган төлөөгүй, тайлан, мэдээнд тусгаагүй буюу өмнө нь ногдуулсан АМНАТ-ийн дүн, суутгасан төлбөрийн дүнг тооцох боломжгүй тохиолдолд энэ журмын 3.4, 3.5-д заасныг үл харгалзан АМНАТ төлөгч нь худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон өөрийн хэрэгцээнд ашигласан бүх төрлийн ашигт малтмалд ногдох төлбөрийг төсөвт төлж, тайлагнана.

4.8. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банк нь энэ журмын 4.2-т заасны дагуу төсөвт шилжүүлсэн АМНАТ-ийн тайлан, мэдээг татварын албанаас баталсан маягтын дагуу гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор татварын албанд хүргүүлнэ.

4.9. Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээдээс бусад АМНАТ төлөгч нь тухайн улиралд олборлож



худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, төлбөрийн нийт хэмжээг мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус байгууллагад хүргүүлнэ.

Тав. Хяналт тавих

5.1. Тухайн сард экспортолсон ашигт малтмалын бүтээгдэхүүний мэдээг Гаалийн ерөнхий газар дараа сарын 5-ны өдрийн дотор Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газарт цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.2. Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь энэ журмын хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж ажиллана.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС

Болон

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)

хоорондын

**ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ
ХӨТӨЛБӨР**

2020-2021 ОНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮҮНЭЭС:

(А) Монгол Улсын Улаанбаатар хотноо Монгол Улс, АХБ 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (“Ерөнхий хөтөлбөр”)-ийг байгуулсан. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр соёрхон батлагдаж, хууль болсон.

(Б) Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги (2017-2020), Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2019-2021) болон Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2020-2021)-ний дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улс, АХБ 2020 оны 2 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын Улаанбаатар хотноо Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг байгуулсан.

(В) Коронавирусын халдварын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах хүрээнд Монгол Улс, АХБ нь шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр (цаашид “Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр” гэх)-ийг байгуулахаар болсон бөгөөд коронавирусын халдвар 2019 (COVID-19)-ийн цар тахлаас үүссэн эсхүл үүсэж болох хүндрэлийг бууруулах хүрээнд Монгол Улс 2020-2021 онд хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор АХБ-наас АХБ-ны зээлийн нөхцөлийн дагуу зээлийн санхүүжилт хүсэж болно.

ИЙМЭЭС талууд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 1.01. Дор дурдсан Хэсэг 1.02, 1.03 болон 1.04-т заасны дагуу COVID-19 цар тахлаас үүссэн эсхүл үүсэж болох хүндрэлийг бууруулах хүрээнд Монгол Улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор АХБ зээлийн санхүүжилт олгож болно. Эдгээр хөгжлийн төсөл нь эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбаруудад чиглэх ба хөгжлийн хөтөлбөр нь COVID-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулахад Монгол Улсад дэмжлэг үзүүлнэ.

Хэсэг 1.02 Зээлийн санхүүжилтийн хэмжээ нь энгийн болон хөнгөлөлттэй энгийн эх үүсвэрийн гурван зуун сая ам.доллар (\$300,000,000)-оос хэтрэхгүй байна. Монгол Улс нь энэхүү эх үүсвэрийг урьдчилан баталгаажсан дүн гэдгийг хүлээн зөвшөөрсөн. АХБ нь зээлийн нэгдсэн дүнг баталгаажуулна.

Хэсэг 1.03 Хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ-тай байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төслүүд дээр Монгол Улс өөрийн нутаг дэвсгэр дээр гарах нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөх хэлбэрээр санхүүжилт гаргаж болно.

Хэсэг 1.04 АХБ хөгжлийн төсөл, хөтөлбөр тус бүрийн зээлийн санхүүжилтийг Монгол Улсын хүсэлтийн дагуу болон АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны үндсэн дээр олгоно. Энэхүү Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс нь заавал зээл хүсэх, эсхүл АХБ нь заавал зээл олгох үүрэг хүлээхгүй болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 2.01. АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох энгийн зээлийн нөхцөл нь (а) 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн үйл ажиллагааны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.02. АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөл нь (а) 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны



Энгийн үйл ажиллагаа (хөнгөлөлттэй)-ны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.03. Монгол Улс нь АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөгжлийн төсөл эсхүл хөтөлбөрийг АХБ-ны авилгын эсрэг арга хэмжээ, хамгаалал, жендер, худалдан авалт, зөвлөх үйлчилгээ болон зээлийн ашиглалтын бодлогууд мөн холбогдох зээлийн хэлэлцээр болон төслийн баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 3.01. Энэхүү Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг талуудын ил тод байдлын болон эсхүл мэдээлэл хүргэх тухай бодлогын дагуу нийтэд ил тод болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 4.01. Энэхүү Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

Хэсэг 4.02. Энэхүү Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг талууд бичгээр тохиролцсоны дагуу сунгаж болно. Талуудын аль нэг Шуурхай хариу арга хэмжээ авах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг нөгөө талтайгаа зөвшилцсөний үндсэн дээр хүчингүй болгоно.

--Заалтуудын төгсгөл--

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.

Хөтөлбөрийг 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ

төлөөлж

ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР

Сайд

Сангийн яам

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКЫГ

төлөөлж

ПАВИТ РАМАЧАНДРАН

Монгол Улсыг хариуцсан захирал

Суурин төлөөлөгчийн газар

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1,75

Индекс: 200003